

Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/272 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл үйл ажиллагаанд тавигдах шаардлага", хоёрдугаар хавсралтаар баталсан "Шаардлагад дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн дагаж мөрдөх стандарт, норм нормативын жагсаалт" -д дор дурдсан агуулгатай нэмэлт заалт тус тус оруулсугай.

1.1. Нэгдүгээр хавсралтад "3.1.1.4. "Нийтийн болон салбар төмөр замын объект барьж байгуулах" гэж.

1.2. Хоёрдугаар хавсралтад **"ГУРАВ.ТӨМӨР ЗАМ"**

1. MNS 6229:2021 "1520 мм-ийн царигтай төмөр зам. Техникийн ерөнхий шаардлага" стандарт
2. MNS 6060:2010 "Төмөр замын зурвас газарт тавих шаардлага"
3. TB 1002.1-2005 "Төмөр замын гүүр хоолойн зураг төсөл боловсруулах тухай норм"
4. MNS 5833:2010 "Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ"
5. СП 63.13330.2010 Snip 52-01-2003 Гүүр ба хоолой
6. ГОСТ 8267-93 Бетон ба төмөр бетон бүтээц
7. MNS6039:2020 "Илчит тэрэгний техникийн ерөнхий шаардлага"
8. MNS EN 50128 "Төмөр замын ашиглалт –Харилцаа холбоо, дохиолол болон процессын системүүд – Төмөр замын удирдлага, хамгаалалтын системийн программ хангамж"

9. MNS 6313:2012 “Хагас автомат хориглолын шаардлага “

10. “Орон сууцны барилга”-ын БНБД 31-01-10" гэж.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Х.Оюунтуяа/-т даалгасугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН